



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө данснаас хасч, орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн нийт 28,944,000.00 (хорин найман сая есөн зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгийн данснаас хасч, засаж сэлбэн ашиглах зорилгоор, ашиглалтын хугацааг сунган, үнийг шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу Дархан-Уул аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа С.Пүрэвсамдан, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Баасанжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Эзэмшигчийг тогтоон хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 72 дугаар тогтоолын хавсралтын 12, 13 дахь хэсэгт заасан “Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын хөрөнгөд бүртгэлтэй ЗИЛ-130, ТСВ-6 маркийн улсын дугаар 18-33 ДАА, ЗИЛ-433366 ТСВ-6 маркийн 18-34 ДАА улсын дугаартай автомашиныг дуудлагын худалдаагаар худалдах” гэснийг хүчингүйд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002391

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 05 дугаар сарын...*13*...өдрийн  
*13* дугаар тогтоолын хавсралт



Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын данснаас хасч Дархан-Уул  
аймгийн өмчид бүртгэх автомашины жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтанд орсон он	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	ЗИЛ-130 маркийн ТСВ-6, улсын дугаар 18-33 ДАА	1995/1996	1	14,472,000.00	3,500,000.00	3
2	ЗИЛ-433366 маркийн ТСВ-6, улсын дугаар 18- 34 ДАА	1995/1996	1	14,472,000.00	3,500,000.00	3
3	Нийт дүн		2	28,944,000.00 (хорин найман сая есөн зуун дөчин дөрвөн мянга )	7,000,000.00 (Долоон сая)	